

## ДӨРВӨЛЖИН БИЧИГТ УРТ ЭГШГИЙГ ТЭМДЭГЛЭХ ЗАРЧИМ

Б.Даваасүрэн

**Резюме:** Авторы в данной статье затронули вопрос об интервокальной согласной буквы  $\alpha$  'a', именуемая в тибетской грамматике как, *a chung*. Данная проблема затрагивалась учёными монголооведами и ранее, однако до настоящего времени остаётся все же открытым и до конца не разрешенным. Интервокальная  $\gamma/g$  старомонгольского письма в квадратном письме Пагба-ламы замещается тибетским полугл-асным  $\alpha$  'a', которая не читается. Тибетское письмо на базе, которого была создана квадратное письмо является абугидой, где гласные буквы выражаются не самостоятельными буквами как в старомонгольском письме или же вообще при фонетическом письме, а специальными диакритическими знаками. Поэтому графически в квадратном письме неуместно писать вслед за какой-либо гласной буквы другую гласную. Иными словами диакритический значок, выражающий какую-либо гласную букву в квадратном письме, обязательно присоединяется к определённой базовой согласной. Эту функцию и выполняет полугласный  $\alpha$  'a', которая в тибетской грамматике считается нулевой морфемой, т.е., которая не читается или же не произносится, но пишется при письме.

**Түлхүүр үг:** *Дөрвөлжин бичиг, төвөд бичиг, санскрит бичиг, тэг авиалбар, дэвсгэр үсэг, үсэг зүй*

Төвөд хэлний их *a* (ᠠ) ба шанаган *a* (ᠠ) гийгүүлэгч хоёулаа монгол хэлний *a* эгшиг мэт дуудагддаг боловч дөрвөлжин бичигт хэрэглэгддэг үүрэг, байрлал, үсэг зүйн онцлог зэрэг нь адилгүй юм.

Монгол бичигт урт эгшгийг тэмдэглэдэг  $\alpha + \gamma/g + \alpha$  гэсэн үе бүтцэд орсон хоёр эгшгийн дундах  $\gamma$  гийгүүлэгчийг дөрвөлжин бичигт чухам яагаад төвөд хэлний шанаган *a* (ᠠ) гийгүүлэгчээр тэмдэглэх болсон асуудлыг авч үзэхийн тулд юун түрүүнд төвөд хэлний шанаган *a* (ᠠ) гийгүүлэгч болон төвөд хэлний их *a* (ᠠ) гийгүүлэгчийн талаар буюу энэ хоёр гийгүүлэгчийн үүрэг, хэрэглээ, авианы шинж гэх мэт асуудлыг юун түрүүн тодруулах шаардлагатай болно. Мөн түүнчлэн дөрвөлжин бичгээс хойш зохиогдсон 1684 оны тод бичиг, 1686 оны соёмбо бичиг, 1905 оны вагиндра бичиг, 1945 оны оросжин үсэг бичигт монгол бичгийн урт эгшгийг тэмдэглэдэг  $\alpha + \gamma/g + \alpha$  гэсэн үе бүтцийн авиан зүйн хувьслыг хэрхэн тусгаж ирсэн бэ гэдгийг давхар үзэх хэрэгтэй юм. Цаашилбал, төвөд ба дөрвөлжин бичгийн суурь болсон санскрит бичиг үсгийг нягталж үзэх нь зүйн хэрэг.

**Төвөд хэлний шанаган а (ᠠ) гийгүүлэгч үсгийн үүрэг, хэрэглээ, авианы шинж**

Шанаган а (ᠠ) гийгүүлэгч нь төвөд хэлний 23 дахь гийгүүлэгч үсэг. Эм гийгүүлэгч, хагас эгшиг.

- Толгой ба зүүлтэт үсэгтэй нийлж ордоггүй;
- Үе, үг бүтээхэд *babs*, *phags* - угтвар үсгийн үүргээр орно;
- *mkhas pa'i* “мэргэдийн”, *dpe cha'i* “номын” - задгай үеийн араас залгагдаж харьяалахын тийн ялгал илтгэнэ;
- *rte'u* “унага”, *rnge'u* “ботго” - багасгасан утгатай сул үгийн үүргээр орно;
- *dga'a'o* “баярласан болой”, *bzang pa'o* “сайн болой” - өгүүлбэр төгсгөх сул үгийн үүрэгтэй;
- Төвөд хэлний эгшиг үсгийг заахдаа *ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ* гэх мэтээр шанаган а (ᠠ) үсгийг хэрэглэдэггүй;
- Санскрит хэлний урт эгшгийг тэмдэглэхэд хэрэглэдэг. Жишээлбэл: *ᠠ li*; *kA li*;
- Үеийн адагт орвол урт *ā* мэт дуудагддаг. Эсвэл эгшгээр төгссөн үеийн араас орсон хоёр дахь үеийн угтвар үсгээр орвол *n* гийгүүлэгч мэт дуудагддаг. Энэ талаар Ю.Н.Рерих «В начале вторых слогов двусложных слов буква а буква 'a имеет носовое произношение, причем предшествующий ей гласный часто становится носовым и долгим: *ᠳᠡᠭᠡᠳᠠᠨ* *dge 'dun* “хувраг”, лх. *gēndū*; *ᠪᠬᠠᠵᠢᠭᠦᠷ* *bka' 'gyur* “Ганжуур”, лх. *kāṅg'ur*; *ᠭᠣᠫᠤᠯᠠᠭ* *go 'phang* “Ганжуур”, лх. *gōm-nhaṅ*. В конце слога *ᠠᠴᠢᠭ* *'a chung* долготу гласного элемента слога: *ᠪᠬᠠᠵᠢᠭ* *bka' “приказ”, лх. kā*; *ᠳᠡᠭᠠᠢ* *dga' “радость”, лх. gā*; *ᠮᠬᠠᠨ* *mkha' “небо”, лх. khā*; *ᠮᠳᠠᠭ* *mda' “стрела” лх. dā*» (2001: 29) хэмээн тэмдэглэсэн байдаг. Үүнээ *ᠳᠡᠭᠡᠳᠠᠨ* *dge 'dun* гэдэгт орсон а гийгүүлэгчийг монгол бичигт *ᠭᠡᠩᠳᠠᠨ* *gengdün* гэж хэлний угийн *ng* гийгүүлэгчээр тэмдэглэдэг. Эдгээр үүрэг, хэрэглээн дээр үндэслэж дөрвөлжин бичгийн хоёр эгшгийн дундах сугарсан *ᠶ/g* гийгүүлэгчийг төвөд хэлний шанаган а (ᠠ) гийгүүлэгчээр тэмдэглэхээр оноожээ. Энэ талаар хойно дөрвөлжин бичгийн жишээ баримтад тулгуурлан өгүүлэх болно.

**Төвөд хэлний их а (ᠡ) гийгүүлэгч үсгийн үүрэг, хэрэглээ, авианы шинж**

ᠡ гийгүүлэгч нь төвөд хэлний 30 дахь гийгүүлэгч үсэг. Үр үгүй гийгүүлэгч, хагас эгшиг.

- Толгой ба зүүлтэт үсэгтэй нийлж ордоггүй. Зөвхөн үе бүтээхэд оролцдог;
- Төвөд хэлний эгшиг үсгийг заахдаа *ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ* гэх мэтчилэн их а (ᠡ) гийгүүлэгчид эгшиг үсэг бүтээхэд оролцдог туслах тэмдэг залгадаг;
- Хэл зүйн сул үгийн үүргээр ордоггүй;
- Угтвар ба дагавар үсгийн үүргээр ордоггүй буюу өөрөөр хэлбэл, ямагт нэрийн гол үсэг болдог;
- Санскрит хэлний урт эгшгийг тэмдэглэхдээ их а (ᠡ) гийгүүлэгчийг хэрэглэдэггүй.

**Дөрвөлжин бичигт шанаган а (ᠠ)-аар авиа тэмдэглэсэн тохиолдлууд**

1. Үгийн дунд орсон хоёр эгшгийн дундах уруулын *b*, *m* гийгүүлэгчийг гэж бичдэг. Жишээлбэл: монг.бич.  $\text{ᠠᠢᠯᠡᠳᠦᠪᠡᠰᠦ}$  *üiledübesü* - дөр.бич.  $\text{ᠠᠢᠯᠡᠳᠦᠪᠡᠰᠦ}$  *'euéj-le-du-'e-su*, монг.бич.  $\text{ᠬᠡᠮᠡᠨ}$  *kemen* - дөр.бич.  $\text{ᠬᠡᠮᠡᠨ}$  *k'en*;
2. Монгол бичгийн хамтрахын тийн ялгалын үүрэгтэй  $\text{ᠯᠠᠭ}$  *luᠭ-a* гэдэг сул үгийн *g* гийгүүлэгчийг дөрвөлжин бичигт гэж бичдэг. Жишээлбэл:  $\text{ᠬᠢᠷᠨᠯᠠᠭ}$  *h-rn-lu-*,  $\text{ᠨᠣᠶᠳᠠᠯᠠᠭ}$  *no-yd-lu-*,  $\text{ᠡ᠋ᠣᠲᠡᠭᠦᠰᠠᠭᠠᠯᠠᠭ}$  *'eo-t'eo-gus-lu-*;
3. Монгол бичгийн хэлний эгшгийн араас залгагддаг үйлдэхийн тийн ялгалын -*bar/-ber* хэлбэрийн *b* нь дөрвөлжин бичгийн хэлэнд сугарч  $\text{ᠠᠷ}$  *'ar*,  $\text{ᠡᠷ}$  *'er* болсон. Тиймээс эгшгээр төгссөн үгийн араас  $\text{ᠠᠷ}$  *'ar*,  $\text{ᠡᠷ}$  *'er* хэлбэрийг залгадаг. Жишээлбэл:  $\text{ᠶᠣᠰᠤᠷ}$  *yo-su-'r*,  $\text{ᠰᠡᠳᠠᠬᠢᠯᠢᠶᠡᠷ}$  *sed-k'i-li-ye-r*;
4. Монгол бичгийн нөхцөл үйлийн  $\text{ᠭᠠᠳ}$  *-ᠭad*,  $\text{ᠭᠡᠳ}$  *-ged* нөхцөлийн *g* гийгүүлэгчийг дөрвөлжин бичигт гэж бичдэг. Жишээлбэл:  $\text{ᠣᠯᠤ}$  *o-lu-'d*,  $\text{ᠳᠡᠭᠡᠷᠡ}$  *del-ge-re-'ed*;

**Дөрвөлжин бичигт их а (ᠠ)-аар авиа тэмдэглэсэн тохиолдлууд**

1. Үгийн эхэнд орсон *a* эгшиг үсгийг тэмдэглэдэг. Жишээлбэл: дөр.бич.  $\text{ᠠᠯᠢᠪ}$  *a-li-b*,  $\text{ᠠᠪᠲᠠᠭᠢ}$  *ab-t'u-qi*.
2. Үгийн эхэнд орсон эм үгийн *ö/ü* эгшиг үсгийн титэм махбодын үүргээр ордог. Жишээлбэл: дөр.бич.  $\text{ᠡ᠋ᠣᠯᠡᠭᠡ}$  *"eol-jeé*,  $\text{ᠡ᠋ᠣᠷᠭᠡᠨ}$  *"eor-geon*; дөр.бич.  $\text{ᠡ᠋ᠣᠪᠡᠯ}$  *"eu-beul*,  $\text{ᠡ᠋ᠣᠭᠡᠰ}$  *"eu-ges*.

Төвөд хэлэнд ямагт нэрийн гол үсэг болдог үүргийг үндэс болгосон учир дөрвөлжин бичигт  $\text{ᠠ}$  гийгүүлэгч үгийн нэгдүгээр үеэс хойш ордоггүй, зөвхөн үгийн эхэнд орсон эр үгийн *a* эгшгийг тэмдэглэдэг эсвэл титэм махбодын үүргээр хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, титэм махбод үгийн дунд, адагт ордоггүйтэй адил их *a* ( $\text{ᠠ}$ ) гийгүүлэгч дөрвөлжин бичигт зөвхөн үгийн эхэнд тохиолдохоос бус үгийн дунд ба адагт огт тохиолддоггүй. Түүнчлэн дөрвөлжин бичигт үгийн эхэнд орсон эм үгийн *ö/ü* эгшиг үсгийг тэмдэглэхдээ  $\text{ᠠᠡ᠋ᠣ}$  *aeo* /  $\text{ᠠᠡ᠋ᠭᠡᠨ}$  *aeu* гэж их *a* ( $\text{ᠠ}$ ) гийгүүлэгчийг титэм махбодын үүргээр хэрэглэдгийг түүхэн сурвалжаас бэлхнээ харж болно.

Энэ мэт түүхэн сурвалжийн баримтаас үзвэл их *a* ( $\text{ᠠ}$ )-г дөрвөлжин бичигт хэрэглэдэг тохиолдол шанаган *a* ( $\text{ᠠ}$ ) гийгүүлэгчтэй харьцуулахад маш тодорхой бөгөөд хязгаарлагдмал байдаг. Дээр дурдсанчлан төвөд хэлэнд их *a* ( $\text{ᠠ}$ ) гийгүүлэгч угтвар ба дагавар үсгийн үүргээр ордоггүй үүргийг нь дөрвөлжин бичигт шууд авч хэрэглэсэн гэж үзэж болно. Дөрвөлжин бичгийн баримтаас харахад зөвхөн монгол бичгийн урт эгшгийг тэмдэглэдэг  $\text{ᠠᠶᠢᠭᠢᠰ}$  гэсэн үе бүтцэд орсон хоёр эгшгийн дундах *g* гийгүүлэгчийг гэж бичиж байсан төдийгүй ерөөс хоёр эгшгийн дунд орсон *b*, *m* гийгүүлэгч, нөхцөл үйлийн  $\text{ᠭᠠᠳ}$  *-ᠭad*,  $\text{ᠭᠡᠳ}$  *-ged*-ийн  $\text{ᠭᠢᠭᠠᠳ}$  гийгүүлэгч үйлдэхийн тийн ялгалын -*bar/-ber* хэлбэрийн *b* нь дөрвөлжин бичгийн хэлэнд сугарсан зэргийг орчин цагийн монгол хэлэнд урт эгшгээр дуудаж бичдэг болсныг басхүү харгалзах хэрэгтэй юм.

Шанаган *a* ( $\text{ᠠ}$ ) гийгүүлэгчийн талаар бичсэн эрдэмтдийн саналыг нэг бүрчлэн дурдах нь илүүц тул доор зарим нэг эрдэмтдийн чухал хэмээн үзсэн саналыг дурдсан болно.

Юуны өмнө хоёр эгшгийн дунд тохиолддог дөрвөлжин бичгийн шанаган а (ᠠ) гийгүүлэгч нь соёмбо, тод, вагиндра бичигт урт эгшгийг тэмдэглэдэг уртатгалын тэмдгийн үүрэгтэй байсан уу, эсвэл уртатгалын тэмдэг бус харин хоёр эгшгийн дунд байсан гийгүүлэгч суларсан ч хараахан ижилсэж амжаагүй эгшиг авианы дотоод бөөгнөрөл (хиатус, гиатус) байсан уу гэдэг асуудал юм.

Тэгвэл дөрвөлжин бичгийн шанаган а (ᠠ) гийгүүлэгчийн тухайд Г.Д.Санжеев “В тех случаях, когда интервокальная “гамма” СМА оказывается в составе долготных комплексов, тогда она соответствует той букве КВП, которая нами условно и не отнюдь не блестящим образом называется буквой “айн” (Хоёр эгшгийн дундах “гамма” урт эгшгийг тэмдэглэдэг үеийн бүтцэд байвал тэр нь дөрвөлжин бичгийн бидний болзмолоор нэрлэсэн “айн” үсэгтэй тохирдог) (1977: 143)”.

Мөн Б.Я.Владимирцов “Монгольское квадратное письмо, основывавшееся, повидимому, на диалекте высшего монгольского обещества XIII-XIV вв., однообразно отмечает исчезновение  $\gamma$ -g. При помощи буквы, восходящей к тиб. ᠠ ḥ, квадратное письмо обозначало между-гласный гиатус, например: *hi-ru-her* (*hiru'er*) «благпожелание, молитва» || монг.-письм. *irügel*; *a-ri-huè* (*ari'ue*) «чистый» || монг.-письм. *ariyun*; *ᠶaḥan* (*ᠶa'an*) «царь, император» || монг.-письм. *qayan*... Китайские транскрипции монгольских текстов XIV в. тоже указывают на исчезновение  $\gamma$ -g между двумя гласными, напр.: *huja'ur* «корень, происхождение», *hula'an* «красный», *hüle'ü* «остаток» (“XIII-XIV зууны үеийн Монголын дээдэс язгууртны хүрээнд хэлэлцэж байсан аялгуунд суурилсан байж болох монгол дөрвөлжин бичигт  $\gamma$ /g сугарсныг тогтвортой тэмдэглэсэн байдаг. Төвөд хэлний ᠠ үсгээс үүсэлтэй үсгээр хоёр эгшгийн дундах гиатусыг тэмдэглэдэг байжээ. Жишээ нь: *hi-ru-her* (*hiru'er*) «ерөөл» || монг.-письм. *irügel*; *a-ri-huè* (*ari'ue*) «ариун» || монг.-письм. *ariyun*; *ᠶaḥan* (*ᠶa'an*) «хаан» || монг.-письм. *qayan*... XIV зууны үеийн монгол хэлээр буй сурвалжуудын хятад галигт мөн адил хоёр эгшгийн дундах  $\gamma$ /g сугарсныг тэмдэглэсэн байдаг. Жишээлбэл: *huja'ur* «язгуур», *hula'an* «улаан», *hüle'ü* «илүү»”) (1989: 214)” хэмээн тус тус тэмдэглэснээс бид Б.Я.Владимирцовын энэхүү саналтай холбогдуулан бид өөрсдийн байр сууриа илэрхийлэхийг зорьсон болно.

Хэрэв дөрвөлжин бичгийн хоёр эгшгийн дунд амьсгалын түрэлтгүй хөөмийн *h* байсан гэж үзвэл төвөд хэлний дуугүй ᠬ *ha* гийгүүлэгчээр тэмдэглэж болох бүрэн боломжтой байсан. Гэвч дөрвөлжин бичигт авиа бүрийг (эр үгийн *q/γ* эс тооцвол) өөр өөр үсгээр тэмдэглэдэг зарчимтай тул үгийн эхэнд орсон бие даасан фонемын үүрэгтэй, дуудагддаг байсан хөөмийн *h* фонемтой адил үсгээр тэмдэглэх боломжгүй юм. Тэмдэглэж болох байсан гэвэл ᠬ ᠰ ᠤᠯ ᠡ ᠬ *h-s-'ul-č'* → ᠬ ᠰ ᠤᠯ ᠡ ᠬ *h-s-hul-č'*, ᠬ ᠢ ᠷ ᠤ ᠡ ᠷ *hi-ru-'er* → ᠬ ᠢ ᠷ ᠤ ᠡ ᠷ *hi-ru-her*, ᠬ ᠠ ᠨ *q-n* → ᠬ ᠠ ᠨ *q-hn* гэх мэт болно. Тиймээс хоёр эгшгийн дунд орсон хөндий *h*-г тэмдэглэхэд үгийн эхэнд орсон ᠬ-тай адил дуудагдах болох учир шанаган а-аар тэмдэглэх аргыг сонгожээ. Түүнчлэн төвөд хэлний зүйд шанаган а (ᠠ) гийгүүлэгчийг тэг авиалбар (нулевая фонема) гэж үздэг буюу энэ нь хоёр эгшгийн дунд авиалж дуудагддаггүй авиалбарыг хэлдэг. Энэ шинжээрээ дөрвөлжин бичгийн хоёр эгшгийн дунд шанаган а (ᠠ) гийгүүлэгч орвол дуудахгүй гэсэн үг юм. Мөн эгшиг авианы дотоод бөөгнөрөл (хиатус, гиатус) алтай овгийн буюу залгамал хэлний эгшиг авианы тогтолцоонд огт байдаггүй. Монгол бичгийн ᠬᠠᠯᠢ *qauli*, ᠬᠠᠯᠢ *taulai* гэдэгт орсон *ai* бол эгшиг авианы дотоод бөөгнөрөл (хиатус, гиатус) биш харин энэ хоёр эгшгийн дундах  $\gamma$  гийгүүлэгч сугарсны л ул мөр, баталгаа юм. Тиймээс монгол хүн уншихдаа *хаули*, *таулаи* гэж огт уншдаггүй, *хууль*, *туулай* хэмээн урт эгшгээр уншдаг. Улмаар а эгшиг ухарч ижилсээд урт эгшиг үүссэнийг монгол бичигт ᠬᠠᠯᠢ *quuli*, ᠬᠠᠯᠢ *tuulai* гэх мэтээр бичих ямар ч боломжгүй. Өөрөөр хэлбэл, энэ мэт үг

ᠭᠠᠯᠢ *qauli*, ᠭᠠᠯᠠᠢ *taulai* гэх хэлбэрээр царцаж үлдсэн бөгөөд бид нэгэнтээ уламжлалт буюу түүхэн бичлэгтэй үг хэмээн нэрлэж заншжээ.

Нөгөөтээгүүр төвөд хэлний эгшиг авиаг тэмдэглэдэг  $\mathfrak{e}$ ,  $\mathfrak{u}$ ,  $\mathfrak{o}$  - *i*, *u*, *e*, *o* нь авиан бичиг буюу цагаан толгойг үсэгтэй адил өөр өөр биеэ даасан үсэг бус туслах тэмдэг юм. Монгол бичгийн *a*, *o*, *u*, *e*, *ö*, *ü*, *i* гэсэн авиаг  $\mathfrak{a}$  ·  $\mathfrak{o}$  ·  $\mathfrak{u}$  ·  $\mathfrak{e}$  ·  $\mathfrak{o}$  гэх мэтээр үгийн эхэн, дунд, адагт тус тус бие даасан үсгээр тэмдэглэдэг. Харин дөрвөлжин бичигт  $\mathfrak{e}$ ,  $\mathfrak{u}$ ,  $\mathfrak{o}$  гэсэн туслах тэмдгийг үсэг зүйн хувьд өмнө орсон эгшгийн араас шууд бичих боломжгүй, заавал ямар нэг гийгүүлэгчийн араас залгаж бичдэг учир хоёр гийгүүлэгчийн дунд байсан *y/g* сугарсныг илтгэхээс гадна хоёр эгшиг үсгийг зааглах үсэг зүйн үүрэгтэй гэж үзэж болно. Хэрэв эгшгийн араас шууд эгшиг бичнэ гэвэл, жишээлбэл:  $\mathfrak{Z} \mathfrak{L} \mathfrak{Q} \mathfrak{y}-'u \rightarrow \mathfrak{Z} \mathfrak{J} \mathfrak{y}-u$ ,  $\mathfrak{B} \mathfrak{L} \mathfrak{Q} \mathfrak{L} \mathfrak{Q} \mathfrak{Z} \mathfrak{Q} \mathfrak{L} \mathfrak{B} -du-'u-sun \rightarrow \mathfrak{B} \mathfrak{L} \mathfrak{Q} \mathfrak{J} \mathfrak{Z} \mathfrak{Q} \mathfrak{L} \mathfrak{B} -du-u-sun$  гэх мэтээр бичихэд хүрнэ. Төвөд ба дөрвөлжин бичиг нь үет үсэг учир ингэж нэг эгшгийн араас шууд өөр эгшиг бичих боломжгүй. Абугида үет үсгийн эгшиг залгах нэг онцлог нь энэ юм.

Гэтэл дөрвөлжин бичигт үгийн дунд дэвсгэр гийгүүлэгчийн араас х гийгүүлэгч орсон тохиолдолд уг  $\mathfrak{L}$  гийгүүлэгчийг бичдэг бөгөөд  $\mathfrak{L}$ -ийн арын эгшиг өргөлтгүй богино дуудагддаг. Жишээлбэл:  $\mathfrak{E} \mathfrak{H} \mathfrak{L} \mathfrak{q}r-q$ ,  $\mathfrak{W} \mathfrak{Z} \mathfrak{H} \mathfrak{L} \mathfrak{Z} \mathfrak{L} \mathfrak{Q} \mathfrak{jir-qo-}'n$ ,  $\mathfrak{H} \mathfrak{Z} \mathfrak{L} \mathfrak{L} \mathfrak{Q} \mathfrak{bol-qn}$ ,  $\mathfrak{W} \mathfrak{Z} \mathfrak{L} \mathfrak{t}'m-q$  гэх мэт.

Харин тод, соёмбо, вагиндра бичигт тухайн үеийн богино эгшгийг уртаар дууд гэсэн тэмдгийг дөрвөлжин бичгийн шанаган а ( $\mathfrak{L}$ ) гийгүүлэгчтэй адилтган үзэж болохгүй юм. Өөрөөр хэлбэл, тод, соёмбо, вагиндра бичигт хэрэглэдэг уртатгалын тэмдэг бол туслах тэмдэг юм. Монгол бичиг V зууны үед зохиогдсон гэж үзвэл дөрвөлжин бичиг 800 жилийн дараа, тод бичиг 415 жилийн дараа, соёмбо бичиг 2 жилийн дараа, 259 жилийн дараа оросжин бичиг дамжиж монгол хэлний зүй эгшгийн тогтолцоо хэрхэн өөрчлөгдсөөр ирснийг тод томруун харж болно. Энэ талаар бид дараагийн ажилдаа дэлгэрэнгүй тусгах болно.

### Ном зүй

- Владимирцов Б.Я.** 1989. *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия*. Москва.
- Лувсанвандан Ш.** 1967. *Дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлд эгшгийн урт богиныг ялгасан нь*. Хэл зохиол IV боть. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш.** 1967. *Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд*. Хэл зохиол IV боть. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш.** 1975. *Монгол дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлийг галиглах тухай асуудалд*. Хэл зохиол судлал XI боть. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш.** 1980. *Дөрвөлжин үсгийн шанаган  $\mathfrak{L}$  - ийн тухай асуудалд*. Хэл зохиол судлал XIV боть. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш.** 1980. *Монгол дөрвөлжин үсгийн их а шанаган а-ийн тухай асуудалд*. *Studia Mongolica* VI (14) боть. Улаанбаатар.
- Санжеев Г.Д.** 1977. *Лингвистическое введение в изучении истории письменности монгольских народов*. У-У., 161 х.
- Рерих Ю.Н.** 2001. *Тибетский язык*. М.
- Поппе Н.Н.** 1941. *Квадратная письменность*. Москва-Ленинград.
- Санжеев Г.Д.** 1953. *Сравнительная грамматика монгольских языков*. Москва.
- Ууганбаяр М.** 2022. *Монгол дөрвөлжин бичгийн шанаган а үсгийн тухай*. Хэл зохиол судлал. Боть XV (47). Улаанбаатар.